

# Хит парад

Жил бүрийн эцэст 102.5 радио станцууд сонсогчдийн саналыг хамгийн их авсан дуунуудын жагсаалтыг гаргадаг.

102.5 радио уг жагсаалтыг гаргахаасаа өмнө сонсогчдын дунд уралдаан зарладаг. Энэ уралдааны үеэр хөтлөгчид дуунуудын эзэлсэн байрын талаар зарим мэдээллийг өгөөд аль болох олон дууны байрыг таахыг санал болгоно.

Жишээ нь доорх хоёр мэдээллийг авч үзье:

- “Дуу минь, дуу минь” дуу эхний гурван байранд багтсан
- “Маамуу нааш ир” болон “Манай цэцэрлэгт тоо заасан” дуунууд эхний хоёр байранд багтсан.

Дээрх мэдээллийг ашиглан “Дуу минь, дуу минь” дуу гуравдугаар байранд орсныг хэлж болно.

Өгөгдсөн мэдээллүүдийг ашиглан эзэлсэн байрыг нь олж болох бүх дуунуудыг олох програм бич.

## Input

Эхний мөрөнд мэдээллийн тоо болох  $N$  натурал тоо өгөгдөнө ( $1 \leq N \leq 500$ ).

Дараагийн  $N$  ширхэг мөрөнд “A of B song1 song2 ... songA” хэлбэртэй мэдээлэл байх ба энэ нь эхний  $B$  байранд song1, song2, ..., songA дуунууд багтсан гэсэн үг.

Дууны нэр нь латин цагаан толгойн жижиг үсгүүдээс тогтсон, 20-оос илүүгүй урттай байна. Мэдээллүүд дотор гарах дуунуудын нийт тоо нь 500-гаас хэтрэхгүй.

Мэдээллүүд хоорондоо зөрчилдөхгүй ба байрыг нь тодорхойлж болох дуу дор хаяж ганц байна.

## Output

Байрыг нь тодорхойлж болох бүх дуунуудыг гаргана. Дуу бүрийг нэг мөрөнд “байр дуу” гэсэн хэлбэрээр, байрны өсөх дарааллаар гаргана.

## Example

**Input:**

2

1 of 3 boroo

2 of 2 tsas mundur

**Output:**

3 boroo

**Input:**

3

2 of 2 duu1 duu2

3 of 4 duu1 duu3 duu4

1 of 3 duu4

**Output:**

3 duu4

4 duu3

**Input:**

4

1 of 4 neg

2 of 3 hoyor gurav

1 of 1 duruv

1 of 4 hoyor

**Output:**

1 duruv

4 neg